

ИТГЭЛИЙН ТУНХАГ



Итгэлийн Тунхагийн Тайлбар

Назар Чуулганы суурь сургаалыг үндсэд нь "Итгэлийн Тунхаг" гэж нэрлэдэг. Эдгээр 16 тунхаглал нь манай теологийн үндсэн онцлог юм. Энэхүү тайлбар нь Итгэлийн Тунхагийг цэцэглэх болон хоорондоо хэрхэн холбогдогдогойг ойлгоход туслах энгийн арга билээ. Мөн Назарын итгэл үнэмшлийн талаар мэдэхийг хүсч буй хүнд тайлбарлаж өгөхөд туслах хамгийн амархан арга болно. Нэмэлт материалыг studymaps.org-оос авна уу.

Эхний гурван тунхаг нь бидний итгэдэг Бурханыг илэрхийлдэг.

1. **Гурвал Бурхан** — Бид мөнхийн, хязгааргүй оршигч нэг Бурханд итгэдэг. Үүнийг гурвалжингаар дүрсэлсэн.
2. **Есүс Христ** — Бид Есүс Христэд итгэдэг. Бурхан хүн төрөлхтөнд ямар их хайртайг мэдүүлэхийн тулд бидэнд үйлчлэхээр ирсэн учраас Түүнийг өвдөг оөгдөн, дуулавартайгаар залбиран буйгаар дүрсэлсэн.
3. **Ариун Сүнс** — Бид Ариун Сүнсэнд итгэдэг. Галын дөл бүхий тагтаагаар дүрсэлсэн.
4. **Ариун Бичээс** — Бид Ариун Бичээст итгэдэг. Номны зураг нь Бурханы Үгийн бичээсийг илэрхийлж байна.

Дөрөвдүгээр Тунхаг нь Бурханы тухай өгүүлсэн эхний гурван тунхагийн гүүр, харин таваас аравдугаар тунхаг нь хүн төрөлхтөн гэм нүглээс Бурхантай харилцах төгс харилцаа уруу орсныг харуулж байна.

5. **Гэм: Төрөлх буюу Хүний** — Төрөлх буюу хувь хүний гэм нүгл байдаг бид итгэдэг. Хоёр талаас нь хэзсэн агимар Адамын төрөлх гэм нүгл болон бидний хувийн гэм нүглийг харуулсан.
6. **Эвлэрүүлэл** — Загалмай дээрх Есүсийн үхлээр дамжуулан бидэнд эвлэрүүлэл ирсэнд бид итгэдэг. Хэзсэн агимны дээд талд загалмайг дүрсэлсэн нь загалмай гэмийг дийлсэн гэсэн утгатай.
7. **Утгал нигүүлсэл** — Утгал нигүүлсэл бол Бурханы бэлэг гэдэгт бид итгэдэг. Задлахад бэлэн хайрцагтай бэлэний зургаар харуулсан.
8. **Гэмшил** — Бид гэмшилд итгэдэг. Дээш тахиралдсан сумаар гэмээс шинэ амьдрал уруу хийж буй эргэлтийг харуулсан. Гэмшил бол Бурханы өршөөлд даруусан найдсаны улмаас хүний хандлага бодитоор өөрчлөгдөхийг хэлнэ.
9. **Зөвтгөл, Шинэчлэл, Үрчлэл** — Бид зөвтгөл, шинэчлэл, үрчлэлд итгэдэг.
 - **Зөвтгөл** — Шүүгчийн алх Бурханы шүүлтийг төлөөлдөг бөгөөд Тэр биднийг нигүүлсэнгүйгээр өршөөж, зөвтөд тооцон, цагаатгасан. (Ром 3:21-26).
 - **Шинэчлэл буюу Шинэ Төрөлт** — Нялх хүүхэд нь Бурханы нигүүлслээр бид шинэ хүн болсныг харуулсан. (Иохан 3:2, Коринт 5:17).
 - **Бурханы хүүхэд болж үрчлэгдэх** — Хөтлөлцсөн аав хүүгээр Бурханы нигүүлслээр бид хүүхэд нь болон үрчлэгдсэнийг харуулжээ. (Ром 8:15-17).

10. **Бүрэн Ариусгал** — Бид бүрэн ариусгалд итгэдэг. Зүрхэн доторх тагтааны зургаар бүрэн ариусгал нь Бурхантай хамт алхаж, Түүнийг сонсон, хүслийг нь гүйцэлдүүлэхийн тулд зүрхэнд (цагаан тагтаа) хийгддэг цэвэрлэгээ ба хүч (гал) гэдгийг бэлгэджээ. Энэ нь Эзэн Бурханаа бүх зүрх, оюун ухаан, сэтгэлээрээ мөн хөршөө өөрийн адил хайрла гэсэн үг билээ.

11-14-р Тунхагт чуулган болон чуулганы итгэлийн гурван мөн чанарыг тусгасан.

11. **Чуулган** — Бид чуулганд итгэдэг. Байшингийн дотор талыг харуулсан зургаар Чуулган бол байшин барилга биш харин Есүсээр дамжуулан Бурханы нэгтгэсэн итгэгчдийн нэгдэл болохыг харуулсан. Тоосго болгоны дотор хүн байгаа нь чуулганы гишүүн бүр хоорондоо холбоотой бөгөөд Бурханд биднийг захирахыг, биднээр дамжуулан гэрэлтэхийг хүсч байгааг илэрхийлсэн. Зүүн талын хананд дутсан тоосго бол Чуулган бол "өөр хэн нэгэн биш" гэдгийг хэлж байна. Бид хоосон зайгаа нөхдөг, Христэд итгэх хүмүүсийн дотор Бурханы үйлчлэлд зориулан өөрсдийн бэлгүүдийг авчирдаг Чуулганы нэг хэсэг байх нь чухал.
12. **Баптисм** — Бид Христэд баптисмд итгэдэг. Бурханы зарцаар усанд булхуулах гэж байгаа хүнээр баптисм хүртэх гэж байгааг дүрсэлсэн.
13. **Эзэний Зоог** — Бид Эзэний Зоогт итгэдэг. Талх ба аяганы зургаар Эзэний Зоогийн хоёр талыг харуулжээ.
14. **Тэнгэрлэг Эдгэрэл** — Бид тэнгэрлэг эдгэрэлд итгэдэг. Бурхан уруу хандан залбирч байгаа хүн бол өвчтэй нэгэн бөгөөд тэнгэрлэг эдгэрлийг авах гол түлхүүр бол залбирал гэдгийг харуулсан.

Сүүлийн хоёр Тунхаг ирээдүйд болох Христийн ирэлт ба бидний хувь тавилангийн тухай тухай өгүүлдэг.

15. **Христийн Хоёр дахь Ирэлт** — Есүс дахин ирнэ гэдэгт бид итгэдэг. Үүнийг Есүс үхл хөлөгтөн тэнгэрээс ирж байгаагаар дүрсэлсэн.
16. **Үхлээс амилах, Шүүлт ба Хувь Тавилан** — Бид үхлээс амилах амилалт болон, шүүлтэд итгэдэг. Сайныг үйлдсэн нь мөнх амь уруу орж, бузар мууг үйлдсэн нь яллагдах болно. Доод талын зурагнууд нь үхлээс амилж буй хүн, шүүгчийн алх нь шүүлтийг, харин дээд талын зурагнууд нь хийсэн зүйлсээсээ болж яллагдсан хүмүүс орох там (гал), мөнхийн улсын хаалганы хажууд зогсон, Есүст итгэж, Бурханы хүслийг биелүүлсэн хүмүүсийн урин оруулж байгаа тэнгэрлэлийг дүрсэлжээ.

CHURCH -  - NAZARENE

Итгэлийн Тунхагийн Тайлбарын зохиогч Sibhane Tabi. Үүнийг ашгийн бус зорилгоор хувилган олшруулж, тарааж болно.